

СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Шинжлэх ухаан, санхүү, инновацыг хөгжүүлэх, тэдгээрийн үр өгөөжийг дэлхийн сүрьеэгийн тахлыг яаралтай зогсоох, ялангуяа урьдчилан сэргийлэх, илрүүлэг, тусламж үйлчилгээгээр тэгш хүртээмжтэй баталгаатай хангах

ҮНДЭСЛЭЛ

Сүрьеэ нь дэлхий даяар нас баралтын тэргүүлэх шалтгаануудын нэг бөгөөд 2021 онд ойролцоогоор 1.6 сая хүн, үүний дотор ХДХВ-ийн халдвартай 187,000 хүн нас барж байна.[1] Сүрьеэгийн эсрэг тэмцэх асуудлаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн дээд хэмжээний хурал 2023 оны 9-р сарын 22-нд Нью-Йорк хотноо “2018 оны улс төрийн тунхаглалд тусгагдсан сүрьеэгийн эсрэг үндэсний, бүс нутаг, дэлхийн түвшинд тохиролцсон зорилтуудын хэрэгжилтэд иж бүрэн дүн шинжилгээ хийх, 2030 он гэхэд тахлыг зогсоох ахиц дэвшлийг хурдасгах цоорхой, шийдлүүдийг тодорхойлох" чиглэлээр боллоо.[2]

Энэхүү Дээд хэмжээний уулзалтын үеэр гишүүн улс орнууд, засгийн газрын тэргүүнүүд, төлөөлөгчид сүрьеэгийн талаарх Улс төрийн тунхаглалыг баталсан.[3] Хэрвээ энэхүү тунхаглал нь биелэгдвэл 2030 он гэхэд сүрьеэ өвчнийг устгаж, 2023-2027 оны хооронд 45 сая хүртэлх хүний амийг аврах боломжтой гэсэн амлалтыг тусгасан байна.[4]

Сүрьеэгийн тухай 2023 оны 84 заалтаас 54 амлалт нь дараах долоон үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан байна:[5]

1 Оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт (48a, 48b, 49, 53-54, 58-р зүйл)

2 Хангалттай, тогтвортой санхүүжилт (21, 25, 28, 59, 62-68, 72-р зүйл)

3 Тэгш бус байдал, сүрьеэгийн ялгаварлан гадуурхал, гутаан доромжлол, хүний эрхийн бусад саад бэрхшээл (37-40, 44, 46-47, 51-53, 58, 61, 65, 67, 71, 74, 77, 80-81-р зүйл)

4 Судалгаа, хөгжүүлэлт (69, 71, 72, 73, 76-р зүйл)

5 Анхан шатны тусламж , ЭМ-ийн тогтолцоог бэхжүүлэх (45, 49, 50-р зүйл)

6 НЭМХ, ББТ, цар тахлын бэлэн байдал (54, 58, 59-р зүйл)

7 Хариуцлага (43, 78, 84-р зүйл)

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

2023 оны 3-р сард APCASO болон түншүүд Сүрьеэ, бүх нийтийн эрүүл мэндийн хамралт (БНЭМХ), цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний талаар (ЦТУСББХАХ) удахгүй болох ЭМГ-ын стратеги, төлөвлөлтийг хийх зорилгоор Индонезийн Жакарта хотод 19 орны 80 иргэний нийгмийн байгууллагуудын түүхэн уулзалтыг зохион байгуулав. Бүс нутгийн иргэний нийгмийн байр суурийг “Эрүүл мэндийн төлөөх уян хатан, тогтвортой, бүрэн нөөцтэй тогтолцоо” [6] -ны талаар мэдэгдэлд тусгаж, бүс нутгийн хувьд хамтын тэргүүлэх чиглэлүүд буюу гол асуултуудыг тодорхойлсон. Хэлэлцүүлгийн ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хуваалцах, Дээд хэмжээний уулзалтын хамтын ажиллагааг улам бэхжүүлэх зорилгоор 2023 оны 7-р сард Бангкок хотноо дээд хэмжээний уулзалтыг угтсан дараа дараагийн уулзалтуудыг зохион байгуулав.

2023 оны 9-р сард батлагдсан улс төрийн тунхаг нь хууль ёсны хүчин төгөлдөр бус боловч үндэсний хэмжээнд болон дэлхийн хэмжээнд БНЭМХ, цар тахлын бэлэн байдал, сүрьеэ өвчнийг таслан зогсоох талаар улс орнуудын хүлээсэн улс төрийн амлалтыг тусгаснаараа ач холбогдолтой байв.

Энэхүү нөлөөллийн товч танилцуулга нь сүрьеэ өвчний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, тархалтыг зогсооход манай олон нийт болон нийгмийг бүхэлд нь илүү сайн татан оролцуулах, мэдээлэл өгөх, чадавхжуулах зорилготой юм. Энэ нь сүрьеэ, эрүүл мэндтэй холбоотой Тогтвортой хөгжлийн зорилтуудыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд бүс нутгийн иргэний нийгмийн оролцогч талуудаас тавьсан таван зүйлт гол асуултуудыг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ засгийн газрууд, дэлхийн удирдагчдад хандан ЦТУСББХАХ, БНЭМХ, сүрьеэгийн эсрэг авах арга хэмжээний талаар тавьсан үндсэн асуултуудыг цохон тэмдэглэсэн . Товчхондоо Сүрьеэгийн талаарх улс төрийн тунхгын хэрэгжилтийг хангахын тулд ИНБ-аас авч болох нэн тэргүүний арга хэмжээг тусгасан.

Сүрьеэгийн ТУХАЙ 2023 ОНЫ ҮНДСЭН АМЛАЛТ

Сүрьеэтэй тэмцэх тухай дээд хэмжээний уулзалт нь “сүрьеэгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй сайжруулах, хүний эрхийг хамгаалах, сүрьеэгийн тодорхойлогч хүчин зүйлсийг шийдвэрлэх, эмзэг байдлыг бууруулах, судалгаа, инновацыг хурдасгах, хангалттай нөөцийг дайчлах асуудлуудруу чиглэсэн зорилт, болон арга хэмжээг багтаасан". [7]

Дараагийн хуудасны хүснэгтэд сүрьеэтэй тэмцэх амлалтуудын[8] үйл ажиллагааны долоон чиглэлийг гишүүн орнууд улс төрийн тунхагт юу амласан талаарх гол ажиглалтуудыг харуулав.

Үйл ажиллагаа	2023 оны Улс төрийн тунхагт тусгагдсан амлалтууд
1 **Оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт**	■ Сүрьеэ өвчнийг зогсоох стратегид тусгагдсаны дагуу ачаалал багатай, өндөр ачаалалтай аль алинд нь сүрьеэгийн тусламж үйлчилгээг цаг тухайд нь, чанартай, бүх нийтэд хүртээмжтэй болгох ахиц дэвшлийг хурдасгаж, 2027 он гэхэд сүрьеэгийн эмчилгээний хамрах хүрээг 90%-д хүргэнэ. 4.5 сая хүүхэд, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 1.5 сая хүртэлх хүн) болон сүрьеэгээр өвдсөн хүмүүсийн 90-ээс доошгүй хувь нь ДЭМБ-аас санал болгосон молекулын түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан байх болно (48а, 53, 58-р зүйл). ■ Олон нийтэд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ, сүрьеэ өвчнийг системтэй илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, халамжлах зэрэг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүрээнд нэгдэхийг амлаж байна (49-р зүйл). ■ Сүрьеэ өвчнөөр өвчилсөн өрхийн 30 сая, ХДХВ-ийн халдвартай 15 сая хүмүүст сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчилгээг 90 хувьтай байлгах (48б. 53, 54, 58-р зүйл). ■ Олон нийтэд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг нэгтгэх (49-р зүйл).
2 **Хангалттай, тогтвортой санхүүжилт**	■ Хангалттай, тогтвортой санхүүжилтийг дайчлах талаар улс төрийн тунхгийн дор хаяж 12 зүйлд иш татсан (21, 25, 28, 59, 62-68, 72). Тухайлбал, сүрьеэгийн дэлхийн санхүүжилтийг 2027 он гэхэд жил бүр 22 тэрбум долларт хүргэж, 2030 он гэхэд 35 тэрбум долларт хүргэж, дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалтын механизм, шинэлэг санхүүжилт, зардалтай/төсөвтэй үндэсний эрүүл мэндийн төлөвлөгөө, стратеги ашиглан дайчлах (62-р зүйл). ■ Улс төрийн тунхаг нь судалгаа хөгжүүлэлтэд хангалттай бөгөөд тогтвортой санхүүжилтийг дайчлах үүрэг амлалтыг агуулсан. Сүрьеэгийн бүх хэлбэрийн оношилгоо, вакциныг хөгжүүлэхэд чиглэсэн сүрьеэгийн судалгаа, инновацад зориулсан дэлхийн нийт хөрөнгө оруулалтыг 2027 он гэхэд жил бүр 5 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьсан.
3 **Тэгш бус байдал, сүрьеэтэй холбоотой ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлол, хүний эрхийн бусад саад бэрхшээл**	■ Ерөнхийдөө улс төрийн тунхаг нь сүрьеэтэй холбоотой ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, хүний эрхийн бусад саад тотгорыг арилгах амлалт, тэгш бус байдалтай тэмцэх талаар хатуу байр суурь агуулсан бөгөөд 19 догол мөрд дурдсан (37-40, 44, 46-47, 51-53, 58, 58-р зүйл) 61, 65, 67, 71, 74, 77, 80-81). ■ Сүрьеэтэй хүмүүс 100% эрүүл мэнд, нийгмийн халамжийн багцад хамрагдах боломжтой бөгөөд ингэснээр тэд өвчний улмаас санхүүгийн бэрхшээлийг даван туулах шаардлагагүй болно (48-р зүйл). ■ Сүрьеэтэй тэмцэх ажлыг эрх тэгш, хүртээмжтэй, хүн төвтэй, жендэрийн тэгш байдлыг дэмжин, хүний эрхийг хүндэтгэх, бодлого боловсруулах форум, төлөвлөлт зэрэгтэй уялдаа холбоотой байхын тулд сүрьеэгийн нөлөөлөлд өртсөн олон нийтийг нэн тэргүүнд тавьж, үндэсний хүчин чармайлтыг эрчимжүүлнэ. Сүрьеэгийн тусламж үйлчилгээг цогцоор нь хүргэх, үндэсний олон салбарыг хамарсан хариуцлагын тогтолцоо, хяналт шалгалтын механизм, олон нийтийн тувшинд санаачилга гаргахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах (78-р зүйл).
4 **Судалгаа, ба хөгжүүлэлт**	■ Улс төрийн тунхгийн таван догол мөр нь судалгаа, хөгжүүлэлт ялангуяа бүх улс орны вакцинаар хангах амлалтад чиглэгддэг. Хөгжиж буй орнуудад судалгаа, хөгжүүлэлтэд ихээхэн ач холбогдол өгч байгааг анхаарна уу (69, 71, 72, 73, 76-р зүйл). 69-р зүйлд, ИНБ-ууд нөлөөллийн кампанит ажилд ашиглаж болох хоёр үндсэн амлалтыг тэмдэглэх нь чухал: а) судалгааны инновацыг хурдасгах, НҮБ-ын гишүүн орнуудын дунд сүрьеэгийн судалгаа, хөгжлийн хамтын ажиллагааг дэмжих судалгаа хийх таатай орчныг бүрдүүлэх; б) сүрьеэгийн судалгааны үр ашиг, хэрэглээнд тэгш хүртээмжтэй байх. ■ Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, тэр дундаа сүрьеэгийн нөлөөлөлд өртсөн олон нийт, иргэний нийгэмтэй судалгаа, хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах тухай эшлэлийг 71, 72, 73-р зүйлд сайн тусгасан бөгөөд сүрьеэгийн тогтвортой, бүрэн санхүүжүүлсэн үндэсний хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхийг онцолсон болно. Үндэсний тэргүүлэх зорилтуудтай нийцэж байгаа нь ИНБ-ын сурталчилгааны сайн хөтөлбөр юм. ■ Сүрьеэгийн эсрэг шинэ вакциныг ойрын таван жилд бүтээж, түүнийг тэгш хуваарилах нь чухал гэдгийг хатуу хэлээр илэрхийлсэн.
5 **Эрүүл мэндийн анхан шатны тусламж, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх**	■ Эрүүл мэндийн тогтолцоо, анхан шатны нэгжийг бэхжүүлэх нь сүрьеэ өвчнийг 2030 он гэхэд таслан зогсоох шаардлага гэдгийг хүлээн зөвшөөрч байна. 45-р зүйлд урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахын тулд нийгмийн эрүүл мэндийн дэд бүтэц, боловсон хүчнийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байгааг дурдсан. НЭМҮТ-ийн хүрээнд олон нийтэд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ, ХДХВ, ДОХ зэрэг сүрьеэ, түүнтэй холбоотой эрүүл мэндийн нөхцөл байдлын системчилсэн үзлэг, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, тусламж үйлчилгээ (49-р зүйл). ■ ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн дундах нас баралтын гуравны нэг нь сүрьеэгийн улмаас, ХДХВ нь сүрьеэгийн эмчилгээний үр дүн муутай холбоотой байдаг тул сүрьеэ-ХДХВ-ийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоог бэхжүүлэх амлалт (50-р зүйл).
6 **Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, бичил биетний тэсвэржилт, цар тахлын бэлэн байдал**	■ Эрүүл мэндийн тогтолцоо, БНЭМХ-г бэхжүүлэх нь сүрьеэ өвчнийг 2030 он гэхэд таслан зогсоох шаардлага онцгой бүрэлдэхүүн, хүчин чармайлтын чухал нэг хэсэг болж байгаа тул ББТ эсрэг асуудлыг хөндөж, ЦТУСББХАХ-г бэхжүүлэх талаар 54, 58-р зүйлд иш татсан. Нэмж дурдахад сүрьеэгийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн ажиллах хүчинд хөрөнгө оруулах амлалт, ДЭМБ-аас санал болгож буй оношилгоо, эмэнд мэдрэмтгий байдлын шинжилгээ, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй хүмүүсийн бүх эмийг уух богино хугацааны эмчилгээний горимыг бүх нийтээр, тэгш, боломжийн үнээр хүртээмжтэй болгохын төлөө ажиллахыг 59-р зүйлд дурдсан.
7 **Хариуцлага**	■ ДЭМБ-ын Сүрьеэгийн олон салбарыг хамарсан хариуцлагын тогтолцоог дэмжих уриалгад сүрьеэгийн нөлөөлөлд өртсөн ард иргэдийн оролцоо, үндэсний нөхцөл байдалтай уялдуулан өндөр түвшний салбар хоорондын хариуцлагын тогтолцоо, хяналт шалгалтын механизмын гол санааг онцолсон (43-р зүйл). 78-р зүйлд хариу арга хэмжээ нь тэгш, хүртээмжтэй, хүн төвтэй, жендэрийн тэгш байдлыг дэмжиж, хүний эрхийг дээдэлсэн байх шаардлагатайг онцгойлон тэмдэглэсэн. 84-р зүйл нь энэхүү Улс төрийн тунхаглалд өгсөн амлалтаа биелүүлэх явцын талаар тайлагнах хүсэлт юм. Энэхүү тайлан нь гишүүн орнуудад хариуцлага тооцох хэрэгсэл бөгөөд олон нийт, иргэний нийгэмд сүрьеэгийн өвчний байдлыг хянах боломж юм.

АЗИ НОМХОН ДАЛАЙН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОГТЛОЛЦСОН АСУУЛТ ▶▶

Энэхүү товч танилцуулгад ИНБ-аас тавьсан таван зүйлээс бүрдсэн гол асуултууд нь сүрьеэтэй холбоотой байсан бол, мөн бидний арга барил эрүүл мэндтэй холбоотой улс төрийн тунхаг дахь цар тахал, сүрьеэгийн талаарх уялдаа холбоог олох явдал байв. ИНБ-ууд БНЭМХ, ЦТББУСХАХ, сүрьеэгийн асуудлуудыг бодитой хэрэгжүүлэхэд саад болж буй асуудлын талаар өргөн хүрээтэй асуулт асуух байсан. Эдгээр огтлолцсон асуултууд нь бидний улс төрийн тунхгаас харахыг хүссэн зарчмууд байсан. Энэ нь БНЭМХ, ЦТББУСХАХ, Сурьеэгийн эсрэг хариу арга хэмжээ нь тэгш, хүртээмжтэй, хүн төвтэй, шударга, эрх тэгш, жендэрийг шилжилттэй, олон нийт, иргэний нийгмийг хамарсан, хариуцлагатай байх ёстой гэсэн үг юм.

Бид асуултуудыг бүгдийг нэгтгэсний дараа улс төрийн тунхагт харилцан уялдаа холбоог хангаагүйг анзаарсан. “Нэг эрүүл мэндийн хандлагын үнэ цэнэ”, “Эрүүл мэндэд олон салбарыг хамарсан хандлагыг” улс төрийн тунхагт дурдсан хэдийч БНЭМХ, ЦТББУСХАХ, сүрьеэгийн уялдаа холбоотой холбоотой тодорхой заалт байхгүй. Үүнийг бид улс орнууд эдгээр асуудлуудын хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэхийн тулд интеграцчлалын хүрээг цаашид хөгжүүлэх иргэний нийгмийн нэвтрэх цэг гэж үзсэн.

ИНБ болон APCASO нь БНЭМХ, ЦТББУСХАХ, сүрьеэгийн нэгдсэн тогтолцоогүй байгаа цоорхойг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж, засгийн газрууд болон дэлхийн удирдагчдад хандан дараах уриалгыг гаргаж байна. Үүнд:

■ "Эрүүл мэндэд тэсвэртэй, тогтвортой систем"-ээс **"Эрүүл мэндэд тэсвэртэй, тогтвортой, нэгдсэн систем" рүү шилжих**. Засгийн газрууд сүрьеэгийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн бус үйлчилгээг БНЭМХ-ийн тогтолцооны нэг хэсэг болгон нэгтгэх; БНЭМХ-ийн үндэс суурийг цар тахлын үед тэсвэрлэх чадвартай болох; тахлын үед БНЭМХ болон сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээг цар тахлын үед тогтвортой хэрэгжүүлэх боломжийг бий болгох.

■ **Хүмүүсийн чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжид нөлөөлж буй нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсэд анхаарах**. Засгийн газар хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах эрхэд нөлөөлж буй урт хугацааны болон системийн асуудлуудад хариу арга хэмжээ авах боломж олгох тогтолцоо, бодлогыг бэхжүүлж, саад бэрхшээлийг арилгаж, хөтөлбөр, арга хэмжээг уялдуулах ёстой.

- **Сүрьеэ, БНЭМХ, ЦТББУСХАХ-ийн санхүүжилтийг сайжруулах.** Засгийн газар эдгээрийг санхүүжүүлэхийн тулд дотоодын эх үүсвэрээс хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх ёстой, ялангуяа судалгаа, хөгжүүлэлтийн чиглэлээр. Мөн засгийн газрууд олон нийт, иргэний нийгэмд чиглэсэн тодорхой хөрөнгө оруулалтыг олон нийт удирдсан хариу арга хэмжээг дэмжих, сүрьеэ, БНЭМХ, ЦТББУСХАХ-ийн шийдвэр гаргах, засаглалд оролцоход нь хуваарилах ёстой.
- **Салбар хоорондын хөдөлгөөнийг бий болгох замаар сүрьеэ, БНЭМХ, цар тахалд "нийгмийг бүхэлд нь хамарсан" хандлагыг бэхжүүлэх.** Засгийн газар, иргэний нийгэм, техникийн түншүүд сүрьеэ, БНЭМХ, цар тахлын хүрээнд шинээр илрэх болон хурц сорилтуудыг шийдвэрлэхийн тулд олон салбар, хөдөлгөөнүүдийн хоорондын уялдаа холбоог өргөжүүлж, сайжруулах ёстой.

- **Нийгэм, эдийн засаг, улс төрийн хувьд гадуурхагдсан гол, эмзэг бүлгийн хүн амыг улс төрийн тунхгийн 3 зорилтод хүрэх түлхүүр гэж хүлээн зөвшөөрөх.** Системийн хувьд болон түүхэн хөгжлийн явцад гадуурхагдсан олон нийт оршиж тогтнож байгаа ба тэдний хэрэгцээг хангах нь гурван улс төрийн тунхгийн зорилтод хүрэхэд зайлшгүй шаардлагатай гэдгийг засгийн газрууд хүлээн зөвшөөрөх ёстой.

АЗИ НОМХОН ДАЛАЙН ИРГЭНИЙ НИЙГМИЙН ГОЛ АСУУЛТ

Ази Номхон далайн бүс нутгийн улс орны төлөөлөгчид, иргэний нийгмийн байгууллагууд эрүүл мэндийн нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг шийдвэрлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сүрьеэгийн хөтөлбөр болон БНЭМХ-ын уялдаа холбоо, хүний нөөцийг санхүүжүүлэх, чадавхжуулах, сүрьеэгийн цогц арга барилаар, хүний эрхэд суурилсан, хүн төвтэй стратеги, БНЭМХ, цар тахлын ерөнхий зарчмууд ашиглах зэрэг таван **үндсэн асуултыг** тавьсан.

Доорх хүснэгтэд иргэний нийгмийн байгууллагуудын гол асуултууд болон НҮБ-ын улс төрийн тунхаг дахь гишүүн орнуудын амласан амлалт, сул орхигдсон орон зай байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээг үзүүлэв. [9]

Гол асуултууд	2023 оны улс төрийн тунхаг дахь амлалтууд	Улс төрийн тунхаг дахь орхигдсон орон зай
1. Эрүүл мэндийг нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг авч үзэх замаар сүрьеэтэй тэмцэх дэлхийн, бүс нутаг, улс орны хариу арга хэмжээний парадигмыг өөрчлөх.	■ ИНБ-ууд эрүүл мэндийн нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг (39, 42, 44, 62-р зүйл) - эдийн засаг, нийгмийг тодорхойлох хүчин зүйлс, сүрьеэгийн чанартай үйлчилгээнд бүх нийтээр хүрэхэд нөлөөлж буй хөшүүрэг/саад бэрхшээлийг онцолсон лавлагаат тэмдэглэв. ■ 44-р зүйлд ядуурал, хоол тэжээлийн дутагдал, ХДХВ, нийгэм, эдийн засагийн тэгш бус байдал, орон байр/амьдрах нөхцөл хангалтгүй, жендэрийн тэгш байдлыг хангахад тулгарч буй саад бэрхшээл, халдварт бус өвчин зэрэг сүрьеэгийн гол хүчин зүйл, хүчин зүйлийг тодорхойлсон. Энэ нь ИНБ-уудад саад бэрхшээлийг нарийвчлан судалж, нөлөөллийн ажилдаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломжийг олгож байна. ■ Эрүүл мэндийн нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг шийдвэрлэх амлалтуудын хэл нь хамгийн өчүүхэн мэт санагдаж байсан ч ИНБ-ууд түүний үнэ цэнийг олж харсан бөгөөд энэ нь улс орнуудад өөрсдийн үндэсний нөхцөл байдалд тулгуурлан нийгмийн тодорхойлогч хүчин зүйлсийг тодорхойлох уян хатан боломжийг олгодог.	Энэхүү асуулгын агуулга нь сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйлчилгээний хүртээмжийг хязгаарлаж буй тогтолцооны саад бэрхшээлийг шийдвэрлэхэд оршино. ■ Ерөнхийдөө сүрьеэгийн чанартай тусламж, үйлчилгээ авах бүх нийтийн хүртээмжийг хязгаарлаж буй нийгмийн тодорхойлогч хүчин зүйлүүд байгааг тунхагт хүлээн зөвшөөрсөн. Үүнийг дагаж мөрдөх нь сүрьеэгийн бүх хүчин зүйлийг шийдвэрлэхэд чиглэсэн олон салбарын хандлагыг агуулсан сүрьеэгийн үндэсний стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх амлалт юм. ■ Амлалтад дутагдаж байгаа зүйл бол үндэсний хэмжээнд хэрэгжилтэд хяналт тавих тодорхой амлалтууд юм. **Саад тотгорыг тодорхойлохоос гадна гол асуулт бол гишүүн орнууд системийн саад бэрхшээлийг арилгах амлалтаа хэрхэн биелүүлж байгааг хянахын тулд ямар механизм ашиглах вэ?** ■ Хэдийгээр 84-р зүйл нь тунхагийн амлалтуудыг хэрэгжүүлэх **явцад гарсан ахиц дэвшлийн талаар тайлагнах хүсэлт боловч хэллэг нь хариуцлага хүлээхийг уриалж байна. Энэхүү тайлан нь гишүүн орнуудад хариуцлага тооцох хэрэгсэл бөгөөд сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хүрэхэд учирч буй системийн саад тотгорыг шийдвэрлэхэд сүрьеэгийн өвчлөлийн байдлыг хянах олон нийт, иргэний нийгэмд боломж юм.**
2. Олон нийтийн оролцоотой нөлөөлөл (ОНОН) болон хүний эрхийн хөндлөнгийн оролцоо (ХЭХО)-ын санхүүжилтийн цоорхойг арилгахын тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	■ Сүрьеэгийн үндэсний иж бүрэн стратегийг дэмжихэд чиглэсэн шинэлэг санхүүжилтийг ОНОН -д оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гарц гэж үзэж болно (28-р зүйл). ■ Хууль эрх зүй, нийгмийн бодлогын тогтолцоог бий болгох үндэсний хүчин чармайлтыг эрчимжүүлэх амлалт (77-р зүйл) нь ОНОН болон ХЭХО-г санхүүжүүлэх боломжийг бий болгож магадгүй юм. ■ ИНБ-ууд 69-р зүйлд олон нийт удирдсан оролцоонд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг уриалж болох хоёр үндсэн амлалтыг анхаарах нь чухал.	Гол нь засгийн газар, хандивлагчдын зүгээс бүс нутаг болон улс орны түвшинд олон нийтийн оролцоотой нөлөөллийн ажилд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэв. ■ **Тунхаглал нь хангалттай бөгөөд тогтвортой санхүүжилтийн талаархи лавлагаа бүхий 12 догол мөртэй боловч сүрьеэгийн эсрэг олон нийтийн оролцоо, ялангуяа олон нийтийн оролцоотой нөлөөлөл, хүний эрхийн оролцоонд зориулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар тодорхой дурдаагүй байна.**
3 БНЭМХ, сүрьегийн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог бий болгох, бэхжүүлэх	■ Сүрьеэгийн хөтөлбөр болон БНЭМХ-ийн хоорондын уялдаа холбоог бий болгох, бэхжүүлэх (41, 49, 58, 59, 78-р зүйл). ■ Сүрьеэ өвчнийг таслан зогсоох, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх (41-р зүйл). Сүрьеэгийн эсрэг тэмцлийн үнэ цэнийг алдагдуулахгүйн тулд ЦТББУСХАХ-г оруулсан (58-р зүйл). Хоосон хандлагаас зайлсхийхийн чухлыг онцолсон. ■ Сүрьеэтэй тэмцэх үндэсний болон дэлхийн стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болгон, нянгийн тэсвэржилтийг арилгах, ЦТББУСХАХ-г сайжруулах амлалт (49-р зүйл). ■ 2030 он гэхэд сүрьеэг устгах үндсэн шаардлага нь эрүүл мэндийн тогтолцоо, анхан шатны бэхжүүлэх юм. Нийгмийн эрүүл мэндийн дэд бүтэц, ажиллах хүчнийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийж, сүрьеэ болон ХДХВ, ДОХ зэрэг эрүүл мэндийн холбоотой нөхцөл байдал болон сүрьеэгийн эмнэлгийн үйлчилгээг анхан шатны үйлчилгээтэй хүрээнд нэгтгэх (45, 49-р зүйл).	Үүнд анхаарах гол асуудал нь: Шинэлэг технологи, хүн төвтэй хандлагыг оновчтой болгож, сүрьеэгийн үйлчилгээг нэгтгэсэн эрүүл мэндийн байгууллагуудын хамрах хүрээг нэмэгдүүлэх. ■ Сүрьеэгийн хариу арга хэмжээ авахад хүчтэй, уян хатан эрүүл мэндийн тогтолцоо чухал, олон нийтийн оролцоо нь БНЭМХ-ыг ахиулж, үр дүнтэй ЦТББУСХАХ-д хувь нэмрээ оруулах боломжтой, мөн БНЭМХ-д хүрэх ахиц дэвшил нь 2030 он гэхэд сүрьеэг устгахад чухал үүрэг гүйцэтгэдэг зэрэг Сүрьеэ- БНЭМХ-ын уялдаа холбоог бий болгох, бэхжүүлэхийн ач холбогдлыг тунхагд зохих ёсоор хүлээн зөвшөөрсөн. ■ **Хэдийгээр Сүрьеэ- БНЭМХ-ын холбоог бий болгох, бэхжүүлэхэд олон нийт, иргэний нийгмийн оролцоог тунхаглалд бүрэн тодорхойлоогүй байгаа ч тэр орон зайг нөхөхийн тулд холбогдох бусад амлалтуудыг ашиглах боломжтой.**

4 Сүрьеэгийн хөтөлбөрт хүний нөөцийг санхүүжүүлэх, чадавхжуулах асуудлыг нэн тэргүүнд тавих	■ Хангалттай, тогтвортой санхүүжилтийг дайчлах талаар дор хаяж 12 зүйлд иш татсан (21, 25, 28, 59, 62-68, 72). ■ Сүрьеэгийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн ажиллах хүчинд хөрөнгө оруулах амлалтыг 59-р зүйлд дурдсан.	■ Хүний нөөцийн санхүүжилт, чадавхийг бэхжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөхийг засгийн газар болон хандивлагчдад уриалж байна. **Эрүүл мэндийн салбарт ажиллах хүчинд хөрөнгө оруулалт хийх амлалт байдаг боловч хүний нөөцийн санхүүжилтийн эх үүсвэрийн гол зорилтуудын талаар тодорхой дурдаагүй бөгөөд "чадавхи" гэх мэт нэр томьёо нь үйлдвэрлэл, судалгаа, мэдээлэл ашиглах хүчин чадлыг түлхүү илэрхийлдэг. Хүний нөөцийн санхүүжилт, чадавхийг бэхжүүлэх нь үндэсний хэмжээний эрүүл мэндийн төлөвлөгөө, стратегид (62-р зүйл) тусгагдах болно гэж таамаглаж байгаа бололтой.**
5 Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, тусламж үйлчилгээнд тэгш, тогтвортой хүртээмжтэй байхын тулд цогц, хүний эрхэд суурилсан, хүн төвтэй стратегийг ашиглах.	■ Сүрьеэтэй холбоотой ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, хүний эрхийн бусад саад тотгор, тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн амлалтуудыг 19 зүйлд заасан (37-40, 44, 46-47, 51-53, 58, 61, 65, 67, 71,74, 77, 80-81-р зүйл) ■ Тэгш бус байдалтай тэмцэхэд таатай хууль эрх зүй, нийгмийн бодлогын тогтолцоог бий болгох үндэсний хүчин чармайлтыг эрчимжүүлэхийг амлалт (77-р зүйл). 49-р зүйлд олон ниітэд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээг БНЭМХ-д нэгтгэх тухай онцлон дурьдсан бөгөөд илүү өргөн хүрээтэй хамруулах талаар үргэлжлүүлэн сурталчлахын ач холбогдлыг чухалчласан байна. ■ ХДХВ-тэй хүмүүсийн гуравны нэг нь сүрьеэгийн улмаас нас барж байгаа тул сүрьеэ-ХДХВ-ийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоог бэхжүүлэх (50-р зүйл). ■ Хариу арга хэмжээ нь тэгш, хүртээмжтэй, хүн төвтэй, жендерийн тэгш байдлыг дэмжиж, хүний эрхийг хүндэтгэсэн эсэхийг баталгаажуулах (78-р зүйл).	Энэ асуултад хүний эрхэд суурилсан, хүн төвтэй цогц стратеги ашиглахыг онцолсон. ■ Сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээнд тэгш, олон нийт, иргэний нийгмийн оролцоог хангах талаар дурдсан. **Гэсэн хэдий ч сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, тусламж үйлчилгээний тэгш, тогтвортой хүртээмжийг хангахын тулд сүрьеэгийн эсрэг үндэсний хариу арга хэмжээнүүдэд цогц, хүний эрхэд суурилсан, хүн төвтэй стратегийг ашиглахтай харьцуулахад баталгаат хангах талаар хангалттүй дурдсан юм. Улс төрийн тунхагт энэ тухай дурдаагүй.** ■ Сүрьеэгийн эсрэг ДЭМБ-ын олон салбарын хариуцлагын тогтолцоог дэмжих уриалга байна (43-р зүйл). **Асуулт: Энэхүү хариуцлагын тогтолцоо нь иргэний нийгмийн санаачилсан хариуцлагын механизм, санаачлагуудын өөгдлийг хэрхэн нэгтгэх вэ?**

ОЛОН НИЙТ, ИРГЭНИЙ НИЙГЭМ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Хянаж, дүн шинжилгээ хийх: Сүрьеэгийн улс төрийн тунхгийг өөрийн орны нөхцөлд хянаж, дүн шинжилгээ хийж, бодлогын өөрчлөлт, хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойл.

Дайчлах: 2024 онд болох Бичил биетний тэсвэржилтийн дээд түвшний уулзалт болон COP28 зэрэг сүрьеэтэй холбоотой бусад арга хэмжээнүүдийн талаарх хэлэлцүүлэг, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын тулд өөрийн орны олон нийт, ИНБ-уудыг дайчлан гол мессеж, хүсэлтийг хүргэх.

Шахалт үзүүлэх: Сүрьеэгийн талаар 2023 онд гаргасан Улс төрийн тунхаглалд тусгагдсан амлалтаа биелүүлэхийг засгийн газруудад шахалт үзүүлэх, сүрьеэд өртсөн олон нийтийг хамруулсан хүн төвтэй сүрьеэгийн хариу арга хэмжээг бий болгох.

Эхлүүлэх: Улс орон, олон нийт, байгууллагуудад улс төрийн тунхаглалын ач холбогдлын талаар чухал мэдээлэл хүргэхийн тулд үүнийг танилцуулах компанит ажил эхлүүл.

Орчуулах: Хүмүүс БНЭМХ-ын улс төрийн тунхаглалын амлалтыг илүү сайн ойлгохын тулд сүрьеэгийн тунхагыг нутгийн хэлрүү орчуулах.

Бий болгох: Засгийн газрууд амлалтаа биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд сүрьеэгийн эсрэг улс төрийн тунхагийн талаарх олон нийт болон хэвлэл мэдээллийхэнийг мэдлэгтэй болгох.

Цуглуулах: Сүрьеэгийн эсрэг амлалтаа хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох, түншлэлийг бэхжүүлэх зорилгоор ИНБ, олон нийт, хандивлагчид болон засгийн газруудтай дээд хэмжээний уулзалтын дараах цуврал яриа хэлэлцээг зохион байгуулах.

Тохируулж, нэвтрүүлэх: Дээд түвшний 3 уулзалтын амлалтуудын төлөв байдлыг хянах механизмын нэг болох APCASO-аас боловсруулж буй БНЭМХ, ЦТББУСХАХ, сүрьеэгийн амлалтуудын Эрүүл мэндийн хариуцлагын үнэлгээний картыг өөрийн улсдаа тохируулж, нэвтрүүлэх.

Нөлөөлөх: Ази Номхон Далайн Иргэний Нийгэмлэгээс гаргасан нэгдсэн асуулгад БНЭМХ, ЦТББУСХАХ, сүрьеэгийн талаарх улс төрийн тунхгуудыг нэгдсэн арга барилаар бүрэн хэрэгжүүлэхэд нөлөөлөх.



Ашигласан материал

1. The high-level meeting on the fight against tuberculosis (Concept Note) <https://cdn.who.int/media/docs/default-source/hq-tuberculosis/tb-hlm-concept-note.pdf?sfvrsn=ce2473cf_3&download=true>.
2. Ibid.
3. New global action pledge to end TB by 2030 <https://aidspan.org/?action=-catelog_singlepost&id=28333>.
4. Ibid.
5. Political Declaration on the High-Level Meeting on the Fight Against Tuber-culosis <https://www.un.org/pga/77/wp-content/uploads/sites/105/2023/09/TB-Final-Text.pdf>; New global action pledge to end TB by 2030 <https://aidspan.org/?action=catelog_singlepost&id=28333>; The second United Nations high-level meeting on TB: new global pledge to end the TB epidemic<https://www.who.int/teams/global-tuberculosis-programme/tb-reports/glob-al-tuberculosis-report-2023/featured-topics/un-declaration-on-tb>; and New global action pledge to end TB by 2030 <https://aidspan.org/?action=catel-og_singlepost&id=28333>.
6. Statement of Asia-Pacific Communities and Civil Society on the 3 HLMs. <https://apcaso.org/resilient-sustainable-integrated-and-fully-resourced-systems-for-health-civil-society-and-communities-statement-on-the-3-hlms/>.
7. The second United Nations high-level meeting on TB: new global pledge to end the TB epidemic. <https://www.who.int/teams/global-tuberculosis-programme/tb-reports/global-tuberculosis-report-2023/featured-topics/un-declaration-on-tb>.
8. Political Declaration on the High-Level Meeting on the Fight Against Tuber-culosis <https://www.un.org/pga/77/wp-content/uploads/sites/105/2023/09/TB-Final-Text.pdf>; and New global action pledge to end TB by 2030 <https://aidspan.org/?action=catelog_singlepost&id=28333>.
9. Some aspects of the analysis were based on the presentation of Mangala Namasivayam, APCASO Program Manager during the 3 HLMs Post-Mortem: What Happened? What's Next? An Asia-Pacific Regional Civil Society Conven-ing, 6 December 2023 Bangkok, Thailand.

APCASO нь нөлөөллийн болон олон нийтийн тогтолцооны чиглэлээр ажилладаг бүс нутгийн иргэний нийгмийн сүлжээ байгууллага юм.

Хаяг 66/5, 33 Tower Soi Sukhumvit, 33 Sukhumvit Road, Klongton Nua, Wattana, Bangkok 10110 Thailand

ИМЭЙЛ secretariat@apcaso.prg Веб сайт www.apcaso.org

МСТХ нь Монгол Улсад төдийгүй бүс нутаг, олон улсад сүрьеэтэй тэмцэхэд үйлсэд хувь нэмрээ оруулдаг байгууллага юм.

Боловсруулсан баг
Мангала Намасивям, зохицуулагч
Мариа Лени И. Феликс, Зохиолч
Мариа Виржиня М. Торрес, Редактор
Виктор Деннис Т. Ниерва, Дизайнер

Орчуулсан баг
Ханджавын Даваажав, орчуулагч
Мөнхжаргалын Ганзориг, орчуулагч, өрөлт
Цогтын Базаррагчаа, Редактор

APCASO-г зохих ёсоор дурдаж энэхүү материалыг арилжааны бус зорилгоор хуулбарлаж эсвэл орчуулж болно.